



МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

ДУГААР

НУУЦЫН ЗЭРЭГ

ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

ТАНИЛЦАХ

ХАРИУЦАХ НЭГЖ

БОЛОВСРУУЛСАН

Гарын үсэг	
Нэр, албан тушаал	О.Баттүшиг, Эрсдэл, комплайнсын албаны дарга

ХЯНАСАН

Гарын үсэг	
Нэр, албан тушаал	Л.Цолмон, Гүйцэтгэх захирал

ӨӨРЧЛӨЛТ

Хувилбар	Тэмдэглэл
1.0	2025 оны 09-р сарын 24-ний өдөр шинээр боловсруулсан.

	ГАРЧИГ	Мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журам						
	ДУГААР		ХУВИЛБАР	1.0	НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛ	C1	ХУУДАСНЫ ДУГААР	2

МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1.1. Зорилго

Энэхүү Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам (“Журам”)–ын зорилго нь Финко Капитал ББСБ ХХК (“Компани”)–ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийтэд тайлагнах, хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хамрах хүрээ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан болон Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч энэхүү Журмыг дагаж мөрдөнө. Энэхүү Журмыг аливаа сонирхогч этгээдийн хүсэлтээр танилцуулж болох ба Компанийн цахим хуудаст байршуулж болно.

1.3. Хяналт, нэмэлт өөрчлөлт

Энэхүү Журмыг Эрсдэл, комплайнсын алба 3 жил тутамд хянаж шаардлагатай бол түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ТУЗ–д танилцуулах ба аливаа өөрчлөлтийг ТУЗ баталснаар хүчин төгөлдөр мөрдөнө.

1.4. Журмын нөхцөл

Энэхүү Журам болон Компанийн Дүрэм (“Дүрэм”)–ийн хооронд зөрүү үүссэн тохиолдолд Дүрэм давуу хүчинтэй байх ба энэ Журам нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй тохиолдолд сүүлд батлагдсан хуулийн зүйл, хэсэг, заалт давуу хүчинтэй байна. Энэхүү Журмын заалтууд хэрхэн тайлбарлах талаар тодорхойгүй байдал, санал зөрөлдөөн үүссэн, Журамд тусгагдаагүй аливаа асуудал гарсан тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, зааврыг дагаж мөрдөнө.

1.5. Нэр томьёо

Энэхүү Журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 1.5.1. **Дотоод мэдээлэл эзэмшигч** гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77 дугаар зүйлд¹ заасан этгээдийг;
- 1.5.2. **Мэдээллийг нээлттэй болгох** гэж хууль тогтоомж, Компанийн засаглалын кодекс болон энэ Журамд заасан мэдээллийг Компанийн цахим хуудас, эсхүл бусад мэдээлэл солилцох хэрэгслээр холбогдох этгээдэд саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр дамжуулан хүргэхийг;
- 1.5.3. **Нийтийн хүртээл болгох** гэж Компани нь холбогдох хууль тогтоомж болон энэ Журамд заасан дотоод мэдээллийг Компанийн болон Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”)–ноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад олон нийтийн хэрэгслээр дамжуулан хүргэхийг;

¹ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

77 дугаар зүйл. Дотоод мэдээлэл эзэмшигч

77.1. Дараах этгээдийг дотоод мэдээлэл эзэмшигч гэж үзнэ:

77.1.1. үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд;

77.1.2. албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээд.

77.2. Энэ хуулийн 77.1–д заасан этгээдийг уг мэдээллийг шууд болон шууд бусаар олж авсан эсэхээс үл хамаарч дотоод мэдээлэл эзэмшигч гэж үзнэ.

	ГАРЧИГ	Мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журам						
	ДУГААР		ХУВИЛБАР	1.0	НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛ	C1	ХУУДАСНЫ ДУГААР	3

- 1.5.4. **Тухай бүр мэдээлэх** гэж энэ Журамд заасан тухай бүр мэдээлэх мэдээллийг тухайн үйл явдал болсон даруй холбогдох журмын дагуу нийтэд мэдээлэхийг;
- 1.5.5. **Хугацаат тайлан** гэж Компаниас хувьцаа эзэмшигчдийн хуралд болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан баримт бичгийг; болон
- 1.5.6. **Эрх бүхий албан тушаалтан** гэж ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-өөс эрх бүхий албан тушаалтнаар тооцсон бусад этгээдийг ойлгоно.

2. Хугацаат тайлагналын мэдээлэл

- 2.1. Компанийн хугацаат тайлагналд жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан хамаарах бөгөөд Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 04-р сарын 30-ны өдрийн дотор энэ Журмын 2.2-т заасан агуулгаар Компанийн цахим хуудсаар дамжуулан болон СЗХ-д хүргэнэ.
- 2.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
- 2.2.1. Компанийн үйл ажиллагаа, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт;
- 2.2.2. Хөндлөнгийн аудиторын баталгаат захидал;
- 2.2.3. Санхүүгийн тайлан тэнцэл, тодруулга;
- 2.2.4. Санхүүгийн жилд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;
- 2.2.5. Тайлант жилд Компанийн үйл ажиллагаа, орлогод нөлөөлсөн гадаад, дотоод орчны нөлөөллийн талаарх мэдээлэл;
- 2.2.6. Компанийн төлбөрийн болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд;
- 2.2.7. Санхүүгийн байдал, нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх мэдээлэл;
- 2.2.8. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл;
- 2.2.9. ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн хороод, гүйцэтгэх удирдлагын удирдлагын чиг үүрэг, хариуцлагын талаарх мэдээлэл болон ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
- 2.2.10. Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;
- 2.2.11. Шаардлагатай тохиолдолд СЗХ-ноос баталсан үнэлгээний аргачлалын дагуу Компанийн засаглалыг үнэлсэн үнэлгээний тайлан;
- 2.2.12. Нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын мэдээлэл;
- 2.2.13. Шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.
- 2.3. Энэхүү Журмын 2.2-т заасан мэдээллийг бүрдүүлэх, мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг Компани, мэдээллийг нийтийн хүртээл болгох зөвшөөрлийг гүйцэтгэх удирдлага, мэдээллийг цаг хугацаанд нь нийтийн хүртээл болгох, Компанийн цахим хуудсанд байршуулах ажлыг Эрсдэл, комплайнсын алба хариуцна.

	ГАРЧИГ	Мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журам						
	ДУГААР		ХУВИЛБАР	1.0	НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛ	C1	ХУУДАСНЫ ДУГААР	4

3. Тухай бүр мэдээлэх мэдээлэл

- 3.1. Компани нь дор дурдсан үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 3 өдөрт багтаан СЗХ-д хүргүүлнэ. Үүнд:
- 3.1.1. Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гэрээ, хэлцлийн талаар мэдээлэл;
 - 3.1.2. Өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд алдаа гарсан бол энэ талаар мэдээлэл;
 - 3.1.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ТУЗ-ийн дарга, гишүүдийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл;
 - 3.1.4. Компанийн Дүрэмд орсон өөрчлөлтийн талаар мэдээлэл;
 - 3.1.5. Шинэ техник, технологи нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрхийн талаар мэдээлэл;
 - 3.1.6. Оноосон нэр, хаяг байршлын өөрчлөлт, салбар, төлөөлөгчийн газрын талаар мэдээлэл;
 - 3.1.7. Үйл ажиллагааны чиглэл, түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон эсэх талаар мэдээлэл; болон
 - 3.1.8. Төлбөрийн чадваргүй болох, Компанийг татан буулгах шийдвэрийн талаар мэдээлэл.
- 3.2. Энэхүү Журмын 3.1-т заасан мэдээллийг бүрдүүлэх, мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг Компани, мэдээллийг нийтийн хүртээл болгох зөвшөөрлийг ТУЗ эсвэл хувьцаа эзэмшигчид, мэдээллийг цаг хугацаанд нь СЗХ-д хүргүүлэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга тус тус хариуцна.

4. Мэдээллийг нийтийн хүртээл болгох

- 4.1. Компанийн цахим хуудсаар дамжуулан нийтийн хүртээл болгосон мэдээллийг Компанийн албан ёсны мэдээлэл гэж үзэх бөгөөд Компани нь бусад олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Компанийн талаарх мэдээллийг хүргэж болно.
- 4.2. Компанийн цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээлэл болон Компанийн засаглалын кодекст заасан бодлогын баримт бичгүүд, дотоод дүрэм, журам, зааврыг байршуулж, цаг тухайд нь шинэчлэн оролцогч талуудыг мэдээллээр хангана.
- 4.3. Компани нь дотоод мэдээллийг дор дурдсан хэлбэрээр нийтийн хүртээл болгоно. Үүнд:
- 4.3.1. Компанийн цахим хуудсаар;
 - 4.3.2. СЗХ-ноос тогтоосон журмын дагуу хэвлэн нийтлэх; болон
 - 4.3.3. Тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр.
- 4.4. Энэ Журмын 2.2-т заасан мэдээллийг нийтэд болон СЗХ-д хүргэх, Журмын 3.1-д заасан мэдээллийг СЗХ-д хүргэхдээ СЗХ-ноос тогтоосон нэгдсэн маягт, зааврыг баримтална.

5. Мэдээллийг нийтийн хүртээл болгоход тавигдах хязгаарлалт, хориглох зүйл

- 5.1. Компани нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно. Нээлттэй болгосон мэдээлэлд алдаа, зөрүү гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч залруулна.

	ГАРЧИГ	Мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журам						
	ДУГААР		ХУВИЛБАР	1.0	НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛ	C1	ХУУДАСНЫ ДУГААР	5

5.2. Дотоод мэдээлэл эзэмшигч нь энэхүү Журам болон Компанийн бусад холбогдох журамд заасны дагуу мэдээллийг нийтийн хүртээл болгохоос өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар бусдад мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.

5.3. Компаниас гаргаж буй аливаа мэдээлэл нь энэхүү Журмын 1.4-т заасан эрх зүйн баримт бичгүүдэд нийцсэн байна.

6. Хариуцлага

6.1. Энэ Журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээр бол тухайн төрийн эрх бүхий байгууллагад хандаж зөрчлийн асуудлыг шийдвэрлүүлнэ.

6.2. Хэрэв хамаарах бол, энэхүү Журмыг зөрчсөн этгээдэд дээр 6.1-т зааснаар хариуцлага хүлээлгэхээс гадна Компанийн дотоод журам болон холбогдох гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.3. Энэ Журмыг зөрчсөнөөс үүссэн хохирлыг хариуцлага ногдуулсан эсэхээс үл хамааран Компанийн буруутай ажилтан, албан тушаалтан хариуцаж арилгана.